



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/366

Номгон

Бага насны хүүхдийн цогц хөгжлийн стратеги  
төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамтарсан багийг  
шинэчлэн байгуулах тухай

Бага насны хүүхдийн үндсэн эрхийг хангах, эрүүл, аюулгүй хөгжих орчинг бүрдүүлэх, зөв хооллох, цэвэр ус уух орчин нөхцөл, ариун цэврийн байгууламжийг зайлшгүй бий болгох, нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бусаар харьцах явдлыг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэн Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 18/18 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бага насны хүүхдийн цогц хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамтарсан багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Дарга: Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол хариуцсан мэргэжилтэн

Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн

Нийгмийн бодлогын хэлтсийн Хүүхэд гэр бүл, жендерийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Боловсрол, соёл, урлагийн газрын Сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч

Цагдаагийн газрын Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Хоол тэжээл, эх хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

621010927

2.


Нарийн бичгийн дарга: Боловсрол, соёл урлагийн газрын дарга

2. Бага насны хүүхдийн цогц хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийхэд салбар дундын хамтын ажиллагааг сайжруулж, удирдлага арга зүйгээр ханган ажиллаж, тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн даргад даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн “Бага насны хүүхдийн цогц хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх хамтарсан баг байгуулах тухай” А/18 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН